



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2024/78/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 70342580 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn Аудитор: Д.Даариймаа Утас: 70342495 Цахим хаяг: daariimaado@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.02.23 № 207

танай _____ ны № _____ т

ОРХОН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ч.ЦАГААНХҮҮ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас Орхон сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Жилийн эцсийн эд хөрөнгө, бараа материалын тооллого хийж, тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 дахь "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана;" 70.2.1 дахь "үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор/;" 70.2.2 дахь "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/;" гэсэн заалтыг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Няrvын тайланд анхан шатны баримт материал дутуу, жолоочийн тооцооны хуудас дутуу энэ нь Нягтлан бодлох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг

006020270

бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

- Иргэдийн хандивыг бэлнээр зарцуулан цагдаагийн байр засварласан боловч баримт материал байхгүй энэ нь Нягтлан бодлох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна
- Сэлбэг хэрэгслийг материалын тайланд орлогодохдоо нэр төрлөөр бус бөөн дүнгээр орлогодсон, зарлагын баримт байхгүй, ямар сэлбэг хэрэгсэл худалдаж авч ашигласан нь тодорхойгүй, техникийн комиссын акт, техникийн тодорхойлолтгүйгээр автомашинд сэлбэг хэрэгсэл авч, засвар үйлчилгээ хийсэн байна энэ нь УСНББОУС 12-г мөрдөж ажиллаагүй, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Орхон сумын Засаг даргын тамгын газар нь орон нутгийн төсвөөс 725849.6, урьд оны үлдэгдлээс 26100.0 мянган төгрөгөөр санхүүжиж, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого 1034.0 мянган төгрөг төвлөрүүлсэн байна

Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 6 зорилтын хүрээнд 46 ажил төлөвлөснөөс гүйцэтгэлээр бүрэн хийгдэж 96.5 хувиар үнэлэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Үлдэх өртөггүй 84938.1 мянган төгрөгийн 68 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй байгаач хөрөнгийн ашиглах хугацааг шинэчлэн тогтоогоогүй, ашиглагдахгүй хэрэгцээгүй хөрөнгийг акталж хөрөнгөөс хасах ажил хийгдээгүй.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжүүлж байгаатай холбогдуулан байгууллагын 5 автомашины дугаарын дэвсгэрийг тус хуулийн 6 дугаар зүйлийн 4-д “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ.” гэж заасны дагуу цэнхэр дэвсгэртэй болгосон байна.

2023 онд шилэн дансанд 159 мэдээлэл тайлагнахаас Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 21 удаагийн 714294.0 мянган төгрөгийн орлогыг мэдээлээгүй, 3 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг

буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл /төгрөгөөр/
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	143,145,459.67	142,683,259.67
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	16,800.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	16,800.00
31210	Төгрөг	0.00	16,800.00
31213	Арилжааны банк дахь харилцах	0.00	16,800.00
35	БАРАА МАТЕРИАЛ	16,322,983.67	15,843,983.67
35100	Түүхий эд материал	13,048,983.67	13,048,983.67
35110	Тусгай зориулалттай материал	13,048,983.67	13,048,983.67
35400	Хангамжийн материал	3,274,000.00	2,795,000.00
35440	Түлш, шатах тослох материал	3,274,000.00	2,795,000.00
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	126,822,476.00	126,822,476.00
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	126,822,476.00	126,822,476.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,792,221,364.05	3,229,675,419.33
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,792,221,364.05	3,229,675,419.33
39200	Биет хөрөнгө	1,552,983,764.05	1,506,538,209.33
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,547,958,310.76	1,547,958,310.76
39202	Хуримтлагдсан элэгдэл	-353,538,269.36	-431,629,171.28
39203	Авто-тээврийн хэрэгсэл	273,099,685.00	334,556,018.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-165,203,231.15	-202,323,954.76
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	160,522,020.49	182,952,020.49
39206	Хуримтлагдсан элэгдэл	-51,797,000.74	-82,007,821.54
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	57,463,434.74	68,583,434.74
39208	Хуримтлагдсан элэгдэл	-35,280,902.43	-56,005,207.35
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,921,960.00	1,921,960.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	164,869,582.82	220,639,582.82
39215	Хуримтлагдсан элэгдэл	-47,031,826.08	-78,106,962.55
39300	Биет бус хөрөнгө	239,237,600.00	1,723,137,210.00
39301	Програм хангамж	1,745,000.00	1,745,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,745,000.00	-1,745,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	239,237,600.00	1,723,137,210.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,935,366,823.72	3,372,358,679.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	285,687.13	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	285,687.13	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	135,687.13	-
41360	Бусад өглөг	150,000.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	150,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,935,081,136.59	3,372,358,679.00
51	Засгийн газрын хувь оролцоо	1,935,081,136.59	3,372,358,679.00
51100	Засгийн газрын оруулсан капитал	487,028,071.65	487,028,071.65
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	487,028,071.65	487,028,071.65
51200	Хуримтлагдсан үр дүн	929,144,006.40	2,366,421,548.81
51210	Өмнөх үеийн үр дүн	771,323,018.55	928,889,206.40
51220	Тайлант үеийн үр дүн	157,820,987.85	1,437,532,342.41
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	518,909,058.54	518,909,058.54
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,935,366,823.72	3,372,358,679.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,073,376,151.80	2,413,517,245.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	320,976,975.00	1,634,089,743.00
120	Нийтлэг татварын бус орлого	320,976,975.00	1,624,489,743.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	473,500.00	1,485,188,410.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	473,500.00	1,034,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	1,484,154,410.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	320,503,475.00	130,826,333.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	8,475,000.00
122	Тусламжийн орлого	0.00	9,600,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	0.00	9,600,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	752,399,176.80	779,427,502.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	218,169,096.00	19,681,442.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	210,821,476.00	18,274,880.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,720,620.00	1,406,562.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	534,230,080.80	759,746,060.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	534,230,080.80	755,949,600.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	0.00	3,796,460.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	741,051,588.95	975,984,902.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	741,051,588.95	975,984,902.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	717,904,105.51	964,802,319.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	249,043,084.00	441,913,644.32
210101	Үндсэн цалин	191,834,549.00	269,886,425.53
210102	Нэмэгдэл	49,153,356.00	118,015,859.47
210104	Урамшуулал	0.00	37,353,739.00
210105	Гэрээт ажлын хөлс	8,055,179.00	16,657,620.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,431,346.49	54,239,061.51
210201	Тэтгэврийн даатгал	21,240,062.18	37,562,660.59
210202	Тэтгэмжийн даатгал	2,497,150.84	4,314,705.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,998,880.75	3,639,740.08
210204	Ажилгүйдлийн даатгал	426,841.16	790,128.07
210205	Эрүүл мэндийн даатгал	4,268,411.56	7,931,827.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	90,680,412.00	131,685,783.24
210301	Гэрэл, цахилгаан	5,083,436.00	7,249,369.39
210302	Түлш, халаалт	85,596,976.00	124,436,413.85
2104	Хангамж, бараа материалын зардал	40,695,796.00	38,401,548.00
210401	Бичиг хэрэг	1,897,750.00	3,619,200.00
210402	Тээвэр, шатахуун	34,682,936.00	29,185,548.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,878,200.00	2,701,850.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	828,910.00	2,581,450.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	408,000.00	313,500.00
2105	Нормативт зардал	3,671,100.00	320,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,671,100.00	320,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	76,110,730.00	17,366,175.00
210604	Урсгал засвар	76,110,730.00	17,366,175.00
2107	Томилолт, зочны зардал	4,818,300.00	9,366,500.00
210702	Дотоод албан томилолт	4,818,300.00	9,366,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,473,530.00	576,306.04
210803	Даатгалын үйлчилгээ	207,300.00	207,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	307,730.00	236,506.04
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	99,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	33,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	217,979,807.02	270,933,301.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	58,838,251.00	71,907,414.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	670,000.00	1,804,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	158,471,556.02	197,221,887.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,147,483.44	11,182,582.76
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,215,500.00	9,368,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.00	8,368,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	1,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,931,983.44	1,813,882.76
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,437,180.44	930,821.76
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,494,803.00	883,061.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	332,324,562.85	1,437,532,342.41
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	157,820,987.85	1,437,532,342.41

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	752,872,676.80	790,061,502.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	473,500.00	10,634,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	473,500.00	1,034,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	473,500.00	1,034,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	473,500.00	1,034,000.00
122	Тусламжийн орлого	0.00	9,600,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	0.00	9,600,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	752,399,176.80	779,427,502.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	218,169,096.00	19,681,442.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	210,821,476.00	18,274,880.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,720,620.00	1,406,562.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	534,230,080.80	759,746,060.00

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	534,230,080.80	755,949,600.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	0.00	3,796,460.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	683,641,176.80	770,094,702.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	683,641,176.80	770,094,702.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	660,493,693.36	758,912,119.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	248,619,408.58	442,199,331.45
210101	Үндсэн цалин	188,345,327.30	270,031,483.66
210102	Нэмэгдэл	47,899,804.28	119,202,568.47
210104	Урамшуулал	12,374,277.00	36,307,659.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	16,657,620.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,325,489.78	54,239,061.51
210201	Тэтгэврийн даатгал	21,715,994.71	37,562,660.59
210202	Тэтгэмжийн даатгал	2,554,834.30	4,419,136.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,043,987.58	3,535,309.08
210204	Ажилгүйдлийн даатгал	455,588.12	790,128.07
210205	Эрүүл мэндийн даатгал	4,555,085.07	7,931,827.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91,174,612.00	131,685,783.24
210301	Гэрэл, цахилгаан	5,083,436.00	7,249,369.39
210302	Түлш, халаалт	86,091,176.00	124,436,413.85
2104	Хангамж, бараа материалын зардал	33,156,240.00	36,593,648.00
210401	Бичиг хэрэг	1,897,750.00	3,206,200.00
210402	Тээвэр, шатахуун	23,637,120.00	24,829,098.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,878,200.00	2,855,850.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,243,170.00	4,387,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	1,315,000.00
2105	Нормативт зардал	3,671,100.00	600,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,671,100.00	600,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	45,948,190.00	17,366,175.00
210604	Урсгал засвар	45,948,190.00	17,366,175.00
2107	Томилолт, зочны зардал	4,718,300.00	9,366,500.00
210702	Дотоод албан томилолт	4,718,300.00	9,366,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,473,530.00	609,306.04
210803	Даатгалын үйлчилгээ	207,300.00	207,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	307,730.00	236,506.04
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	99,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	66,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	197,406,823.00	66,251,814.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	196,636,823.00	64,221,814.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	770,000.00	2,030,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,147,483.44	11,182,582.76
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,215,500.00	9,368,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.00	8,368,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	1,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,931,983.44	1,813,882.76
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,437,180.44	930,821.76
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,494,803.00	883,061.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	69,231,500.00	19,966,800.00

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	69,231,500.00	19,950,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	69,231,500.00	19,950,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	69,231,500.00	19,950,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	39,231,500.00	19,950,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-69,231,500.00	-19,950,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	16,800.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	16,800.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	310,562,471.65	518,909,058.54	771,323,018.55	1,600,794,548.74
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	310,562,471.65	518,909,058.54	771,323,018.55	1,600,794,548.74
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	176,465,600.00	0.00	0.00	176,465,600.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	157,820,987.85	157,820,987.85
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	487,028,071.65	518,909,058.54	929,144,006.40	1,935,081,136.59
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	487,028,071.65	518,909,058.54	929,144,006.40	1,935,081,136.59
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-254,800.00	-254,800.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	487,028,071.65	518,909,058.54	928,889,206.40	1,934,826,336.59
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,437,532,342.41	1,437,532,342.41
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	487,028,071.65	518,909,058.54	2,366,421,548.81	3,372,358,679.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	776,529,500.00	756,052,778.24	-16,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	776,529,500.00	756,052,778.24	-16,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	767,160,800.00	746,684,078.24	-16,800.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	445,049,000.00	442,199,331.45	0.00
210101	Үндсэн цалин	304,153,900.00	270,031,483.66	140,629.00
210102	Нэмэгдэл	100,659,300.00	119,202,568.47	-1,186,709.00
210104	Урамшуулал	11,800,000.00	36,307,659.00	1,046,080.00
210105	Гэрээт ажлын хөлс	28,435,800.00	16,657,620.32	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,631,100.00	54,239,061.51	0.00
210201	Тэтгэврийн даатгал	37,829,100.00	37,562,660.59	0.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,450,500.00	4,419,136.44	-104,431.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,560,400.00	3,535,309.08	104,431.00
210204	Ажилгүйдлийн даатгал	890,100.00	790,128.07	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,901,000.00	7,931,827.33	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	137,121,000.00	131,685,783.24	0.00
210301	Гэрэл, цахилгаан	10,600,000.00	7,249,369.39	0.00
210302	Түлш, халаалт	126,521,000.00	124,436,413.85	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,939,000.00	35,641,268.00	-165,600.00
210401	Бичиг хэрэг	3,675,000.00	3,206,200.00	100,000.00
210402	Тээвэр, шатахуун	26,924,000.00	24,764,218.00	100,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,400,000.00	2,855,850.00	-154,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,140,000.00	3,500,000.00	-212,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800,000.00	1,315,000.00	0.00
2105	Нормативт зардал	900,000.00	600,500.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	900,000.00	600,500.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,317,400.00	31,816,175.00	0.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,000,000.00	19,950,000.00	0.00
210604	Урсгал засвар	12,317,400.00	11,866,175.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	8,800,000.00	7,926,500.00	0.00
210702	Дотоод албан томилолт	8,800,000.00	7,926,500.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	903,300.00	609,306.04	-33,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	296,300.00	207,300.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	420,000.00	236,506.04	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	99,500.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	66,000.00	66,000.00	-33,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,500,000.00	41,966,153.00	181,800.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,500,000.00	39,936,153.00	94,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.00	2,030,000.00	87,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,368,700.00	9,368,700.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,368,700.00	9,368,700.00	0.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,368,700.00	8,368,700.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	776,529,500.00	756,983,600.00	0.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	725,529,500.00	755,949,600.00	755,949,600.00
320001	Орон нутгийн төсвөөс	725,529,500.00	755,949,600.00	755,949,600.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	51,000,000.00	1,034,000.00	-26,100,000.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	1,034,000.00	0.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	45.00	49.00	49.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	1.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	22.00	24.00	24.00
620001	Удирдах ажилтан	8.00	8.00	8.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00	10.00
620003	Үйлчлэх ажилтан	4.00	6.00	6.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	22.00	24.00	24.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8.00	8.00	8.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7.00	9.00	9.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7.00	7.00	7.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	19,140,631.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	19,140,631.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	19,140,631.00
2104	Хангамж, бараа материалын зардал	952,380.00
210402	Тээвэр, шатахуун	64,880.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	887,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,440,000.00
210702	Дотоод албан томилолт	1,440,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,748,251.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,748,251.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	19,681,442.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,681,442.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,274,880.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,406,562.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1550061.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1527695.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 7844.4 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 14521.4 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

1.Хандиваар ирсэн 9600.0 мянган төгрөгийг данс бүртгэлд тусгаагүйг тусгаж залруулсан.

2.Бөөн дүнгээр орлогодсон 4440.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгслийг нэр төрлөөр болгож залруулсан.

3.Шатахууны 26596.3 мянган төгрөгийн орлогыг бөөн дүнгээр орлогодсоныг нэр төрөл литрээр болгож залруулсан.

4.Сэлбэг хэрэгслийн материалд 2650.0 мянган төгрөгийн ажлын хөлсийг орлогодсоныг залруулсан.

5.Газрын гэрчилгээ гарсан 1484154.4 мянган төгрөгийн 15 газрыг нэмж, давхар орлогодсон 254.8 мянган төгрөгийн 1 газрыг хасаж залруулсан.

6.Няравын тайлан дахь шаардах хуудас, анхан шатны баримтууд гарын үсэг, тамга тэмдэггүй, зарлагын баримт анхан шатны баримт материал дутуу, жолоочийн тооцооны хуудас дутуу, жолоочийн тооцооны хуудасгүй 2144.4 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан.

7.Орон тооны бус Улсын бүртгэгчид 200.0 мянган төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон.

8.Жилийн эцсийн эд хөрөнгө, бараа материалын тооллого хийж, тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй.

9. Иргэдийн хандиваар хийгдэх 5500.0 мянган төгрөгийн Цагдаагийн байрны засварын ажлыг дуусгаагүй, мөнгийг бэлнээр данснаас гаргасан ч авлагаар тусгаагүй зөрчил илэрлээ.

10.Сэлбэг хэрэгслийг материалын тайланд 4776.2 мянган төгрөгийн сэлбэг хэрэгслийг нэр төрлөөр бус бөөн дүнгээр орлогодсон, зарлагын баримт байхгүй, техникийн комиссын акт, тодорхойлолтгүйгээр автомашинд сэлбэг хэрэгсэл авч, засвар үйлчилгээ хийсэн.

11.Ур чадварын нэмэгдэл олгохдоо албан хаагчийн ажлын үзүүлэлтийг үнэлж, дүгнэж олгоогүй.

5.1 Төлбөрийн акт

1.Жолоочийн тооцооны хуудасгүй 2144.4 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6, 13.7 дахь заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь:

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасны дагуу төлбөрийн акт хүргүүлсэн.

2. Орон тооны бус Улсын бүртгэгчид түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон.

Шийдвэрлэсэн нь:

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн

аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасны дагуу төлбөрийн акт хүргүүлсэн.

5.2 Албан шаардлага

1. Жилийн эцсийн эд хөрөнгө, бараа материалын тооллого хийж, тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдээгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 дахь “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана” 70.2.1 “үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор/;”, 70.2.2 “түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/;” заалтуудыг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь:

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.2-д “Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй” гэж заасны дагуу албан шаардлага хүргүүлсэн.

2. Сэлбэг хэрэгслийг материалын тайланд орлогодохдоо нэр төрлөөр бус бөөн дүнгээр орлогодсон, зарлагын баримт байхгүй, ямар сэлбэг хэрэгсэл худалдаж авч ашигласан нь тодорхойгүй, техникийн комиссын акт, тодорхойлолтгүйгээр автомашинд сэлбэг хэрэгсэл авч, засвар үйлчилгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэж заасныг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь:

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал.” гэж заасны дагуу албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Ур чадварын нэмэгдэл олгохдоо албан хаагчийн ажлын үзүүлэлтийг үнэлж, дүгнэж олгоогүй нь Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 дүгээр тушаалын хавсралтын 2-д “Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд тогтмол сайн гүйцэтгэдэг буюу бусдаас илүү идэвх санаачилга, өндөр үр дүнтэй ажиллаж байгаа түгээмэл мэргэжлийн албан

хаагчдад дараах үндсэн шалгуур үзүүлэлтийг харгалзан ур чадварын нэмэгдэл олгоно.", 5-д "Ажилтанд олгож байгаа ур чадварын нэмэгдлийг заасан хязгаарт багтаан нэмэгдүүлэх, бууруулах асуудлыг улирал бүр хэлэлцэн шийдвэрлэж байна", 7-д "Ур чадварын нэмэгдлийг ажилтнуудын цалинг нэмэх, амьдрал ахуйг харгалзах зэргээр хавтгайруулан олгохыг хориглоно." гэсэн заалтуудыг зөрчсөн.

Өгсөн зөвлөмж:

Ур чадварын нэмэгдэл олгохдоо албан хаагчийн ажлын үзүүлэлтийг үнэлж, дүгнэж олгох, ажилтанд олгож байгаа ур чадварын нэмэгдлийг нэмэгдүүлэх, бууруулах асуудлыг улирал бүр хэлэлцэн шийдвэрлэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор албан шаардлага, төлбөрийн актын биелэлтийг заасан хугацаанд ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Хандиваар ирсэн 9600.0 мянган төгрөгийг данс бүртгэлд тусгаагүйг тусгаж залруулсан.	1	9600.0	1	9600.0			1	9600.0				
Бөөн дүнгээр орлогодсон 4440.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгслийг нэр төрлөөр болгож залруулсан.	1	4440.0			1	4440.0	1	4440.0				
Шатахууны 26596.3 мянган төгрөгийн орлогыг бөөн дүнгээр орлогодсоныг нэр төрөл литрээр болгож залруулсан.	1	26596.3			1	26596.3	1	26596.3				
Сэлбэг хэрэгслийн материалд 2650.0 мянган төгрөгийн ажлын хөлсийг орлогодсоныг залруулсан.	1	2650.0			1	2650.0	1	2650.0				
Газрын гэрчилгээ гарсан 1484154.4 мянган төгрөгийн 15 газрыг нэмж, давхар орлогодсон 254.8 мянган төгрөгийн 1 газрыг хасаж залруулсан.	1	1484409.2	1	1484409.2			1	1484409.2				
Няравын тайлан дахь шаардах хуудас, анхан шатны баримтууд гарын үсэг, тамга тэмдэггүй, зарлагын баримт анхан шатны баримт материал дутуу, жолоочийн тооцооны хуудас дутуу, жолоочийн тооцооны хуудасгүй 2144.4 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан.	1	2144.4							1	2144.4		
Орон тооны бус Улсын бүртгэгчид 200.0 мянган төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон.	1	200.0							1	200.0		
Жилийн эцсийн эд хөрөнгө, бараа материалын тооллого хийж, тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй.	1								1			
Сэлбэг хэрэгслийг материалын тайланд орлогодходоо нэр төрлөөр бус бөөн	1	4776.2							1	4776.2		

Засаг даргын нөөц хөрөнгөөс зочин төлөөлөгчдөд гарын бэлэг гардуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэсэн заалтыг зөрчсөн.	1	765.0	1	765.0				
Хишиг-Өндөр, Бүрэгхангай сумын 100 жилийн ойд хандив өгсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6 дахь "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх;" Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10 дахь “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн.	1	2000.0	1	2000.0				
Дүн	2	2765.0	2	2765.0			0	0
Нийт дүн	3	717059.0	2	2765.0	0	0	1	714294.0

-oOo-